

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

219. Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 25 849

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

220. Журам батлах тухай Дугаар 19 850
221. “Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч” шагнал олгох тухай Дугаар 26 865
222. Төлөвлөгөө батлах тухай Дугаар 30 869
223. Дүрэмд өөрчлөлт оруулах тухай Дугаар 32 875
224. Хурдан морины бүсийн уралдааны 2012 оны хуваарийг тогтоох тухай Дугаар 37 875
225. Загвар шинэчлэн батлах тухай Дугаар 38 876
226. “Эрүүл хүүхэд” аян зохион байгуулах тухай Дугаар 39 898
227. “Улсын сайн малчин” шагнал олгох тухай Дугаар 42 905
228. Ажлын өдөр шилжүүлэх тухай Дугаар 43 905
229. “ДЦС-5” төслийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 44 906

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- 2012 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Дугаар 25 Улаанбаатар хот

**Дэд хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Байнгын хорооны даргаар томилогдсонтой нь холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энэбишийн Мөнх-Очирыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2. Улсын Их Хурлын гишүүн Наваансамдангийн Ганбямбыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

3. Энэ тогтоолыг 2012 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 1 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 4, 5, 7, 11, 12, 13 дугаар зүйл, Боловсролын тухай хуулийн 39.7, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сургалтын төрийн сангийн дүрэм”-ийг 1 дүгээр, “Сургалтын төрийн сангийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг 2 дугаар, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ыг 3 дугаар, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг 4 дүгээр, “Монгол Улсад эрэлт ихтэй мэргэжлийн жагсаалт”-ыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Их, дээд сургууль, коллежийн аттестатчиллыг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний дотор дуусгах, аттестатчилалд хамрагдаагүй дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид магадлан итгэмжлэлийн үр дүнгээр суралцагчийн тэтгэлэг, зээл олгох арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт даалгасугай.

3. Сургалтын төрийн санд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт нарт тус тус даалгасугай.



4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2000 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 201 дүгээр тогтоол, “Журам, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2001 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 195 дугаар тогтоол, “Журам батлах тухай” Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр
тогтооолын 1 дүгээр хавсралт

СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сургалтын төрийн сан (цаашид “Сан” гэх)-гийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Сангийн зорилго нь дээд боловсролыг санхүүжүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу тэтгэлэг, зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

1.3. Сангийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

1.4. Сан нь хуулийн этгээд байх бөгөөд холбогдох журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, Төрийн сан, Монголбанкинд харилцах данстай байна.

1.5. Сангийн бүтэц, орон тооны дээд хязгаар, суралцагчид олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Хоёр. Сангийн Удирдах зөвлөл

2.1. Сан нь Удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөл нь Сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, хөрөнгийн бүрдүүлэлт,

хуваарилалтын талаар чиглэл өгөх, зарцуулалтад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

2.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Удирдах зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Удирдах зөвлөлийн хурал гишүүдийн 75-аас доошгүй хувь ирснээр хүчинтэйд тооцогдож, асуудлыг хуралд оролцсон гишүүдийн 75-аас дээш хувийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл гаргана. Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй гишүүн саналаа бичгээр өгсөн бол түүнийг хуралд оролцсонд тооцно.

2.4. Ээлжит бус хурлыг шаардлагатай бол Удирдах зөвлөлийн даргын саналаар хуралдуулж болно. Сангийн гүйцэтгэх захирал тодорхой асуудлыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх саналаа зөвлөлийн даргад тавьж болно.

2.5. Удирдах зөвлөл нь Сангийн үйл ажиллагааны тайлан, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх, зээлийг эргэн төлүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Гурав. Сангийн гүйцэтгэх захирал

3.1. Сангийн гүйцэтгэх захирал нь Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилах, зээлийг эргэн төлүүлж Сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зохистой зарцуулах, тайлагнах, хөрөнгийн ашиглалтад хяналт тавих үйл ажиллагааг хариуцна.

3.2. Гүйцэтгэх захирал нь Сангийн ерөнхий менежер байх бөгөөд Сангийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, Сангийн талаар Засгийн газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, ажилтнуудын ажил үүргийн хуваарийг баталж, гэрээ байгуулж дүгнэнэ.

3.3. Гүйцэтгэх захирлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

Дөрөв. Сангийн хөрөнгийн эх үүсвэр

4.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

4.1.1. улсын төсвийн хөрөнгө;

4.1.2. эргэн төлөгдсөн зээлийн хөрөнгө;

4.1.3. хандив, тусламж.



Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

5.1. Сангийн хөрөнгийг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 5.3.3-т заасан арга хэмжээнд зарцуулна.

5.2. Алслагдсан орон нутгаас дээд боловсролын сургалтын байгууллагад ирж суралцагчийн замын зардлыг санхүүжүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

5.3. Сангийн хөрөнгийг хуульд зааснаас өөр үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

Зургаа. Сангийн эрх, үүрэг

6.1. Сан нь дараах эрхтэй байна:

6.1.1. зээл, амьжиргааны зардлын тэтгэлгийн гэрээ байгуулах;

6.1.2. тэтгэлэг, зээл авч байгаа суралцагчийн сурлага, шилжилт хөдөлгөөний талаархи мэдээлэл, зээл, тэтгэлгийн зарцуулалтын тайланг дээд боловсролын сургалтын байгууллагаас авах;

6.1.3. олгосон зээлийг хариуцагч этгээдээс нэхэмжлэх;

6.1.4. олгосон зээлийг эргүүлэн төлөхөөс зайлсхийсэн иргэдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

6.1.5. гадаад, дотоодын сан, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, төсөл хэрэгжүүлэх.

6.2. Сан нь дараах үүрэгтэй байна:

6.2.1.Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, тайлагнах ажлыг зохион байгуулах;

6.2.2.суралцагчид тэтгэлэг, зээл олгох, зээлийн барьцаанд байгаа хөрөнгийн баталгааг бүрдүүлж, эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах;

6.2.3.Сангийн тухайн жилийн төсвийг боловсруулж, улсын төсвийн төсөлд тусгуулах.



Долоо. Бусад

7.1. Сангийн санхүүжилтээр Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын талаархи мэдээллийн санг байгуулж ажиллуулна.

7.2. Сан нь тэтгэлэг, зээлийн гэрээний биелэлтийн асуудлаар дээд боловсролын сургалтын байгууллагад хяналт тавьж ажиллана. Сан нь шаардлагатай бол уг асуудлаар хууль хяналтын байгууллагад хандан ажиллана.

7.3. Сан нь тэтгэлэг, зээлд хамрагдах суралцагчдын бичиг баримтын бүрдүүлэлт, зээлийг эргэн төлүүлэх асуудлаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|------------------|---|
| Дарга | -Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| Дэд дарга | -Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Гишүүд: | <p>-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;</p> <p>-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;</p> <p>-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;</p> <p>-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;</p> |



-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсролын газрын дарга;

-Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын боловсролын асуудал хариуцсан референт;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсролын суралцагчийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

-Сангийн яамны Төсвийн бодлогын газрын боловсрол, соёл, шинжлэх ухааны төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

**Нарийн бичгийн
дарга**

-Сургалтын төрийн сангийн гүйцэтгэх захирал

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр
тогтооолын 3 дугаар хавсралт

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД
СУРАЛЦАГЧИД СУРАЛЦАГЧИЙН ТЭТГЭЛЭГ
ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын аттестатчилагдсан дээд боловсролын сургалтын байгууллагын диплом, бакалавр, магистр, докторын боловсрол эзэмших өдрийн ангид болон хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа Монгол Улсын иргэн, хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд тус тус суралцагчийн тэтгэлэг (цаашид “тэтгэлэг” гэх) олгоход энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан олгох буцалтгүй мэнгэн тусламжийг суралцагчийн тэтгэлэг гэнэ. Суралцагчийн тэтгэлэг нь үндэсний болон урамшууллын тэтгэлэг, сургалтын төлбөр болон амьжиргааны зардал гэсэн хэлбэртэй байна.

1.3. Зохих журмын дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцаж байгаа Монгол Улсын иргэн нь тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргах эрхтэй.

1.4. Дээд боловсролын сургалтын байгууллага нь тэтгэлгийг суралцагчид зохих журмын дагуу тооцож олгоно. Тэтгэлгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

Хоёр. Үндэсний тэтгэлэг

2.1. Монгол Улсын аттестатчилагдсан дээд боловсролын сургалтын байгууллагад зохих журмын дагуу элсэж, суралцах чадвар, идэвх санаачилга, төлөвшлөө илтгэн харуулсан өдрийн ангийн суралцагчид үндэсний тэтгэлэг олгоно.

2.2. Үндэсний тэтгэлгийг нэг хичээлийн жилд 10 хүртэл сарын турш олгоно. Тэтгэлэг олгох нийт хугацаа нь тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөрт заасан жилээс хэтрэхгүй байна.

2.3. Үндэсний тэтгэлэг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээтэй байна.

Гурав. Урамшууллын тэтгэлэг

3.1. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад сурлагын өндөр амжилт гарган суралцаж байгаа болон эрэлт ихтэй мэргэжлээр өдрийн ангид амжилттай суралцаж байгаа суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно.

3.2. Эрэлт ихтэй мэргэжлийн чиглэлийг Засгийн газар тогтооно.

3.3. Урамшууллын тэтгэлгийг үндэсний тэтгэлгийн хэмжээнээс дараахь хувиар тооцон олгоно:

3.3.1. 3.2 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа диплом, бакалаврын зэргийн суралцагчид 50 хувийн;

3.3.2. 3.6 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа диплом, бакалавр, магистр, докторын зэргийн суралцагчид 75 хувийн;



3.3.3. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохион байгуулсан улсын олимпиадад эхний гурван байранд шалгарсан шинээр элсэгчид 100 хувийн;

3.3.4. боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олон улсын олимпиадад оролцож, шагналт байранд шалгарсан шинээр элсэгчид 100 хувийн;

3.3.5 олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр болон гадаадын нэр хүнд бүхий дээд боловсролын сургалтын байгууллагатай хамтарсан хос хөтөлбөрөөр суралцаж байгаа 3.0 болон түүнээс дээш голч дүнтэй суралцагчид 50 хувийн;

3.3.6. эрэлт ихтэй мэргэжлээр элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо нь 720-иос дээш шинээр элсэгчид, 3.0 болон түүнээс дээш голч дүнтэй суралцагчид 50 хувийн.

3.4. Урамшууллын тэтгэлгийг давхардуулан олгохгүй.

Дөрөв. Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал

4.1. Дараахь суралцагчид амьжиргааны зардал олгоно:

4.1.1. хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүй суралцаж байгаа Монгол Улсын иргэн;

4.1.2. хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн.

4.2. Дараахь суралцагчид сургалтын төлбөр олгоно:

4.2.1. бүтэн өнчин бакалаврын зэргийн суралцагч;

4.2.2. хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын зэргийн суралцагч;

4.2.3. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын зэргийн нэг суралцагч;

4.2.4. хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн.

4.3. Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын хэмжээг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

4.4. Сургалтын төрийн сан нь сургалтын төлбөр болон амьжиргааны зардал авах суралцагчтай гэрээ байгуулна. Энэхүү гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

4.5. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хичээлийн жилийн эцэст урамшууллын тэтгэлэг олгох суралцагчийн сурлагын дүнгийн тайланг дээд боловсролын сургалтын байгууллагаас авч, хяналт-шинжилгээ хийж, дүгнэлтийг Сургалтын төрийн санд хүргүүлнэ.

4.6. Суралцагчийн мэдлэгийг бодитой бус үнэлсэн, сурлагын тайланг үнэн зөв гаргаагүй нь нотлогдвол тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

Тав. Бүрдүүлэх бичиг баримт

5.1. Тэтгэлэгт хамрагдах суралцагч нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн суралцаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын захиргаанд өгнө:

5.1.1. тэтгэлэг хүсэх болсон шалтгаанаа тодорхой тайлбарласан өргөдөл;

5.1.2. сурлагын дүнгийн тодорхойлолт;

5.1.3. Боловсролын үнэлгээний төвийн батламж (шинээр элсэгч);

5.1.4. дээд боловсролын сургалтын байгууллагад зохих журмын дагуу элссэнийг нотлох боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрхийн бичиг;

5.1.5. энэхүү журмын 4.1-д заасан суралцагчийн хувьд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;

5.1.6. энэхүү журмын 4.2-т заасан суралцагчийн хувьд эрх бүхий этгээдийн баталгаажуулсан холбогдох бичиг баримт, тодорхойлолт.



Зургаа. Санхүүжилт

6.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь үндэсний тэтгэлэг авах суралцагчийн дэлгэрэнгүй судалгааг улирал бүр гаргаж, Сургалтын төрийн санд хүргүүлнэ.

6.2. Урамшууллын тэтгэлэг авахыг хүссэн суралцагчийн өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч, хянан баталгаажуулах ажлыг дээд боловсролын сургалтын байгууллагын захирлын тушаалаар байгуулсан комисс хариуцан зохион байгуулна. Комисс нь тэтгэлэг авах суралцагчийн талаархи мэдээллийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Сургалтын төрийн санд хүргүүлнэ.

6.3. Сургалтын төрийн сан нь дээд боловсролын сургалтын байгууллагын санал, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн үндэсний болон урамшуулын тэтгэлгийн санхүүжилтийг улирал тутам тухайн дээд боловсролын сургалтын байгууллагад шилжүүлнэ.

6.4. Энэхүү журмын 3.3.3, 3.3.4-т заасан урамшууллын тэтгэлгийн хугацаа нэг хичээлийн жил байна.

6.5. Урамшууллын тэтгэлэг авсан суралцагч чөлөө авсан, эсхүл энэхүү журамд заасан голч дүнгийн шаардлагыг хангаагүй тохиолдолд санхүүжилтийг зогсоно.

6.6. Сурлагын голч дүнгийн шаардлага хангаагүйгээс урамшууллын тэтгэлэг авах эрх нь хасагдсан суралцагч дараагийн хичээлийн жилд голч дүнгийн шаардлага хангавал тэтгэлэг авах эрх нь нээгднэ.

6.7. Энэхүү журмын 4.1.1-д заасан амьжирагааны зардлыг Монгол Улсаас тухайн оронд суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан олгоно. Дипломат төлөөлөгчийн газар нь өөрийн суугаа болон хавсрان суугаа оронд суралцаж байгаа Монгол Улсын иргэний сурлагын дүнгийн талаархи мэдээллийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Сургалтын төрийн санд хүргүүлнэ.

6.8. Энэхүү журмын 4.1.2, 4.2.4-т заасан амьжирагааны зардал, сургалтын төлбөрийг тухайн хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу олгоно. Суралцагчид олгох амьжирагааны зардлын хэмжээг холбогдох хэлэлцээрт тодорхой заагаагүй бол боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр тогтооно. Санхүүжилтийг тухайн суралцагчийн суралцаж байгаа дээд боловсролын

сургалтын байгууллагад шилжүүлнэ. Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн суралцагчийн ирц, дотоод дүрэм, журмын шаардлагыг биелүүлсэн байдлын талаархи мэдээллийг Сургалтын төрийн санд хичээлийн жилийн улирал тутам хүргүүлнэ.

Долоо. Бусад

7.1. Энэхүү журам нь хоёр дахь дээд боловсрол эзэмшиж байгаа суралцагчид хамаарахгүй.

7.2. Сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг санхүүжүүлэх гэрээ, санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомж болон дүрэм, журмаар зохицуулна.

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр
тогтоолын 4 дүгээр хавсралт

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД
СУРАЛЦАГЧИД СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН БОЛОН
АМЬЖИРГААНЫ ЗАРДЛЫН ЗЭЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын болон гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгоход энэхүү журмыг мөрднө.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын болон гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын боловсрол эзэмшихээр зохих журмын дагуу элсэн өдрийн ангид суралцаж байгаа болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад докторын дараахь сургалтад хамрагдаж байгаа Монгол Улсын иргэнд хамаарна.

1.3. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зөвхөн сургалтын төлбөрийн, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгоно.

1.4. Зээлийн гэрээний загвар, зээлийн хэмжээг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

1.5. Тухайн жилд сургалтын төлбөрийн зээл авах суралцагчдын хяналтын тоог боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн



Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор тогтооно. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хяналтын тооны хуваарийг холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлэх ажлыг хариуцна.

Хоёр. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид олгох сургалтын төлбөрийн зээл

2.1. Элсэлтийн ерөнхий шалгалтад 600 болон түүнээс дээш оноо авсан элсэгч, 2.8 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа дараах суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгоно:

2.1.1. хагас өнчин суралцагч;

2.1.2. малчин өрхийн суралцагч;

2.1.3. өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь Үндэсний статистикийн хорооноос тогтоосон бүсийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч;

2.1.4. гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан суралцагч.

Гурав. Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид олгох сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл

3.1. Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг нэг суралцагчид нэг удаа олгоно.

3.2. Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг бакалаврт 2 жил, магистрантад 2 жил, докторантад 3 жил, докторын дараах сургалтад хамрагдагчид 1 жил хүртэлх хугацаатайгаар үл хөдлөх хөрөнгө барьцаалан олгоно.

3.3. Зээлд хамрагдах суралцагчийг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Дөрөв. Бүртгэл, шалгаруулалт

4.1. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч дараах бичиг баримтыг бүрдүүлэн жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний дотор тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын захиргаанд өгнө:

- 4.1.1. өргөдөл;
 - 4.1.2. эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон суралцагчийн иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 4.1.3. бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар;
 - 4.1.4. Боловсролын үнэлгээний төвийн батламж;
 - 4.1.5. сургуульд зохих журмын дагуу элссэнийг гэрчлэх эрхийн бичиг;
 - 4.1.6. үргэлжлүүлэн суралцагчийн дүнгийн тодорхойлолт;
 - 4.1.7. энэхүү журмын 2.1.1-д заасан суралцагчийн хувьд эцэг, эхийн аль нэг нь нас барсныг гэрчлэх бичиг баримтын хуулбар;
 - 4.1.8. энэхүү журмын 2.1.2-т заасан суралцагчийн хувьд малчин өрх болохыг нотлох харьяалах сум, дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт;
 - 4.1.9. энэхүү журмын 2.1.3-т заасан суралцагчийн хувьд харьяалах сум, дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт;
 - 4.1.10. энэхүү журмын 2.1.4-т заасан суралцагчийн хувьд 2 жилээс доошгүй хугацаагаар гэрээт цэргийн алба хаасныг тодорхойлсон харьяалах аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт;
 - 4.1.11. зээлийн баталгаа.
- 4.2. Сургалтын төлбөрийн зээл авахыг хүссэн суралцагчдаас хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулах ажлыг дээд боловсролын сургалтын байгууллагын захирылын тушаалаар байгуулсан комисс хариуцан зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүнд тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын болон оюутны асуудал хариуцсан ажилтан, оюутны байгууллага, суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөлгийг оруулна. Комисс нь энэхүү журмын 4.1-д заасан бичиг баримтыг үндэслэн сургалтын төлбөрийн зээл олгох элсэгч, суралцагчийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор сонгож, дүгнэлтийг Сургалтын төрийн санд хүргүүлнэ.
- 4.3. Дээд боловсролын сургалтын байгууллагаас ирүүлсэн дүгнэлт, суралцагчийн бичиг баримтыг Сургалтын төрийн сан хянан үзэж, тухайн суралцагчид зээл олгох эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.



4.4. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

4.4.1. зээл хүссэн өргөдөл;

4.4.2. Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн хуулбар;

4.4.3. итгэмжлэгдсэн төлөөлөгчөө томилсон тухай итгэмжлэл;

4.4.4. боловсролын баримт бичгүүдийн хуулбар;

4.4.5. зээлийн барьцааны гэрээ;

4.4.6. дээд боловсролын сургалтын байгууллагад суралцуулах урилга, сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын нэхэмжлэл, харилцах данс.

Тав. Зээлийн гэрээ, санхүүжилт

5.1. Сургалтын төрийн сан нь сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл авах суралцагчтай зээлийн гэрээ байгуулна.

5.2. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн зээлийн гэрээнд талуудын эрх, үүрэг, зээлийн санхүүжилтийн хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлийг тодорхой тусгана.

5.3. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн зээлийн гэрээнд энэхүү журмын 5.2-т зааснаас гадна итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тухай мэдээлэл, суралцах хугацаа, дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн чиглэл, гэрээний нөхцөл зөрчигдсэн тохиолдолд талуудын хүлээх хариуцлагыг тодорхой тусгана.

5.4. Сургалтын төлбөрийн зээлийн санхүүжилтийг тухайн суралцагчийн суралцаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын дансанд шилжүүлнэ.

5.5. Сургалтын төлбөрийн зээлд хамрагдаж байгаа суралцагчийн сурлагын голч дүн 2.8 болон түүнээс дээш байх тохиолдолд гэрээг сунгаж, санхүүжилтийг үргэлжлүүлэн олгоно. Сурлагын голч дүнгийн үзүүлэлтээр зээлийн эрх нь хасагдсан суралцагчийн оронд тухайн дээд боловсролын сургалтын байгууллагад нэг хичээлийн жилээс доошгүй хугацаанд 2.8-аас дээш голч дүнтэй суралцаж байгаа суралцагчийг зээлд хамруулж болно.



5.6. Суралцагч нь чөлөө авсан, эсхүл журамд заасан голч дүнгийн шаардлага хангахгүй суралцсан тохиолдолд дээд боловсролын сургалтын байгууллагын албан ёсны мэдэгдэл, саналыг үндэслэн зээлийн гэрээг цуцалж, санхүүжилтийг зогсоно.

5.7. Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын төлбөрийн зээлээр суралцагчийн шилжилт хөдөлгөөний талаархи мэдээллийг 30 хоногийн дотор Сургалтын төрийн санд албан бичгээр мэдэгдэнэ.

5.8. Гадаадад суралцагчийн сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийн гэрээг сунгах, санхүүжилтийг олгох, зогсоох асуудлыг дээд боловсролын сургалтын байгууллагын тодорхойлолт, сурлагын дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

Зургаа. Бусад

6.1. Сургалтын төрийн сан нь сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл авсан суралцагчдын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлж ажиллана.

6.2. Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийн гэрээ, зээлийн санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр
тогтоолын 5 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД ЭРЭЛТ ИХТЭЙ МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТ

1. Авто замын барилга
2. Бага аngийн багш
3. Сургуулийн өмнөх боловсролын багш
4. Байгалийн ухааны чиглэлийн багш
5. Геологи
6. Гидрогеологи
7. Гидромеханик инженер
8. Усны нөөц экологи
9. Уул уурхайн ашиглалтын технологи
10. Уул уурхайн машин, тоног төхөөрөмж
11. Малын эмч
12. Мэдээллийн систем



13. Газрын тосны хадгалалт, тээвэрлэлт
14. Сантехник, инженерийн байгууламж
15. Сэргээгдэх эрчим хүч
16. Нано инженерчлэл
17. Биотехнологи
18. Цөмийн эрчим хүч
19. Онош зүй
20. Эмнэлзүйн шинжлэх ухаан судлал

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 1 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

**“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”,
“Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний
тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч”
шагнал олгох тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан:

-Архангай аймгийн Тариат сумын Цагааннуур багийн малчин Дарамжавын Бямбарагчaa, Батцэнгэл сумын Баян-Уул багийн малчин Самбуугийн Лхагважав, Хашаат сумын Цайдам багийн малчин Осорын Очирболд, Их тамир сумын Хан-Өндөр багийн малчин Хадын Эрдэнэбаатар;

-Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 4 дүгээр багийн малчин Динханы Төрөхан, Баяннуур сумын 4 дүгээр багийн малчин Байтаны Хадай, Улаанхус сумын 6 дугаар багийн малчин Жанатын Шалатай;

-Баянхонгор аймгийн Хүрээмжүүлэлт сумын Цорьж багийн малчин Доржийн Бямбасүрэн, Баян-Овоо сумын Асгамба багийн малчин Шанзандийн Дамдинсүрэн, Эрдэнэцогт сумын Жанжин багийн малчин Доржготовын Батболд, Баянбулаг сумын 3 дугаар багийн малчин Баасанжавын Батдэлгэр;

-Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Хүрээмт багийн малчин Далхын Эрдэнэбат, Сайхан сумын Угалз багийн малчин Даваасүрэнгийн Баярсайхан, Баян-Агт сумын Баянзүрх багийн малчин Намнангийн Жаргалсайхан, Гурванбулаг сумын Тогоо багийн малчин Очирын Ширбазар;

-Говь-Алтай аймгийн Тонхил сумын Алтайн-Оргил багийн малчин Жамъяншаравын Дандар, Тайшир сумын Галуут багийн малчин Чулууны Нямбуу, Төгрөг сумын Тунгалаг багийн малчин Хувцагааны Түмбаатар;

-Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар багийн малчин Дорлигийн Зоригтсайхан;

-Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Санжинт багийн малчин Дашдондогийн Ганболд;

-Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Аманшанд багийн малчин Равдангийн Пүрэвдаш, Алтанширээ сумын Хаяа багийн малчин Бэгзийн Бөхбат;

-Дорнод аймгийн Сэргэлэн сумын 2 дугаар багийн малчин Нямдаваагийн Даваасүрэн, Цагаан-Овоо сумын 3 дугаар багийн малчин Өлзийбатын Өлзий;

-Дундговь аймгийн Хулд сумын Бүлээн багийн малчин Руламын Ойровдорж, Гурвансайхан сумын Элгэн багийн малчин Донторын Дүгэр, Цагаандэлгэр сумын 2 дугаар багийн малчин Самбуугийн Оюунтуяа;

-Завхан аймгийн Түдэвтэй сумын Баянцагаан багийн малчин Уламбаярын Алтанхундага, Эрдэнэхайрхан сумын Алтан багийн малчин Сэдхүүгийн Сэсээр, Их-Уул сумын Цэцүүх багийн малчин Гомбосүрэнгийн Батбаяр, Тосонцэнгэл сумын Идэр багийн малчин Жамъянгийн Цэвээн;

-Орхон аймгийн Баян-Өндөр сумын Малчин багийн малчин Булганы Уламбаяр;

-Өвөрхангай аймгийн Баянгол сумын 3 дугаар багийн малчин Чойсүрэнгийн Отгонбаатар, Бүрд сумын 1 дүгээр багийн малчин Мэндийн Раднаа;

-Өмнөговь аймгийн Булган сумын Хавцгайт багийн малчин Цэвэлийн Валя;

-Сүхбаатар аймгийн Наран сумын 1 дүгээр багийн малчин Цэндийн Эрдэнэбат, Халзан сумын 2 дугаар багийн малчин Рагчаагийн Энх-Амгалан, Түвшинширээ сумын Дэлгэрхаан багийн малчин Цэгмидийн Мижиддорж;

-Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Хонгор-Овоо багийн малчин Дамчаагийн Жамсрэн;



-Төв аймгийн Баян-Өнжүүл сумын 1 дүгээр багийн малчин Жунайн Пүрэв, Эрдэнэсант сумын 3 дугаар багийн малчин Базаррагчаагийн Төрболд, Лүн сумын Өгөөмөр багийн малчин Лэгцэгийн Очирбат, Мөнгөнморьт сумын Байдлаг багийн малчин Магсарын Лхамсүрэн;

-Увс аймгийн Давст сумын Торхилог багийн малчин Цэрэнгийн Баатар, Наранбулаг сумын Алдар багийн малчин Гэндэнгийн Батаа, Зүүнхангай сумын Жаргалант багийн малчин Хөрстийн Хавтгай, Түргэн сумын Баянхайрхан багийн малчин Охидоогийн Отгонбаяр;

-Ховд аймгийн Булган сумын Байтаг багийн малчин Дугаржавын Даваа, Манхан сумын Улаанхүрээ багийн малчин Өлзийбатын Сэсээр;

-Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Шивээ багийн малчин Жавзангийн Дэмбэрэл, Цагаан-Уул сумын Тосон багийн малчин Пүрэвийн Бямбаа, Түнэл сумын Навчилтай багийн малчин Аюурзанын Дашжамц;

-Хэнтий аймгийн Галшар сумын Арвин багийн малчин Цэндийн Батболд, Дэлгэрхаан сумын Долоод багийн малчин Өвгөнхүүгийн Балдандугар, Цэнхэрмандал сумын Согоот багийн малчин Дарьсүрэнгийн Оюун, Хэрлэн сумын Баянмөнх багийн малчин Галсангийн Нарангэрэл нарыг “Улсын сайн малчин”-аар;

2. Дорнод аймгийн Чойбалсан сумын Энгэршанд багийн иргэн Бэхбатын Бэххуяг, Төв аймгийн Баянчандмань сумын Эрдэнэ багийн иргэн Рэнцэнгийн Цогтбуян нарыг “Улсын тэргүүний фермер”-ээр;

3. Говь-Алтай аймгийн Бугат сумын 2 дугаар багийн “Шимт хадлан”, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Шарга багийн “Улиаст”, Төв аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар багийн “Монгол эсгий” малчдын бүлгийг “Улсын тэргүүний малчны бүлэг”-ээр;

4. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Ургац хангай” ХХК, Тэшиг сумын “Шинэ амжилт” ХХК, Хутаг-Өндөр сумын “Хонгор-Агро” ХХК;

-Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Цайдам Өгөөж” ХХК;

-Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын “Ургацын хишиг” ХХК, Түшиг сумын “Гацуурт” ХХК, Хушаат сумын “Өгөөж Мандал-Уул” ХХК, Ерө сумын “Доолт” ХХК;

-Төв аймгийн Эрдэнэсант сумын “Нарт монгол” ХХК, Жаргалант сумын “Алтан залаа” ХХК;

- Хэнтий аймгийн Баян-Адарга сумын “Идэр Онон” ХХК;
- Хөвсгөл аймгийн Тариалан сумын “ЭТҮ” ХХК-иудыг “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор.
- 5. Архангай аймгийн Эрдэнэбулган сумын “Хасу мандал” ХХК-ийн ногоочин Батсамбуугийн Алагмаа;
- Баян-Өлгий аймгийн Сагсай сумын ногоочин Буркитханы Хайрым;
- Булган аймгийн Хутаг-Өндөр сумын ногоочин Дүүрэнгийн Ганбаатар, Булган сумын ногоочин Цэвээний Бат-Өлзий;
- Говь-Алтай аймгийн Чандмань сумын ногоочин Банзрагчийн Оросоо, Есөнбулаг сумын ногоочин Пунцагийн Гансүх;
- Дархан-Уул аймгийн Орхон сумын ногоочин Отгонсүрэнгийн Батпүрэв;
- Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын ногоочин Дашзэвэгийн Эрдэнэсүрэн;
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Сүүтэй” ХХК-ийн тракторч комбайнч Баатарын Нямпүрэв, Цагааннуур сумын “Атар трейд” ХХК-ийн механизкуулагч Уранчимэгийн Хишигжаргал, Орхонтуул сумын “Суварган тамир” ХХК-ийн тракторч, комбайнч Бүдээгийн Буянбат, Шаамар сумын ногоочин Дагвуын Баатарцож;
- Төв аймгийн Угтаалцайдам сумын “Чандмань дөл” ХХК-ийн механизкуулагч Дамдинсүрэнгийн Баатаржав, Жаргалант сумын “Хөх Баянбулаг” ХХК-ийн тракторч, комбайнч Нацагдоржийн Намнандорж, Угтаалцайдам сумын “Элсэн цагаан” ХХК-ийн механизкуулагч Доржбадамын Үржин, Борнуур сумын ногоочин Түvdэнгийн Балдангомбо;
- Хөвсгөл аймгийн Тариалан сумын “Хөвсгөл Алтандуулга” ХХК-ийн механизкуулагч Дарьмаасүрэнгийн Мөнхтогтох;
- Увс аймгийн Баруунтуруун сумын ногоочин Монголын Долгор;
- Ховд аймгийн Жаргалант сумын ногоочин Самбуугийн Лхагважав, Буянт сумын ногоочин Акийн Үлдэрхан нарыг “Улсын тэргүүний тариаланч”-аар тус тус шалгаруулсугай.



5. “Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч”-дад олгох тэмдэг, үнэмлэх, дурсгалын зүйлд зориулж 227.0 (хоёр зуун хорин долоон) сая төгрөгийг төсвийн багцаасаа гарган санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Т.БАДАМЖУНАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гамшигаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулахи замаар санхүүжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд Д.Хаянхярваа, холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт даалгасугай.

2. Гамшигаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулахи замаар санхүүжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд Д.Хаянхярваа, холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт даалгасугай.

3. Гамшигаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийн биелэлт, үр дүнг нэгтгэн, жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД



Засгийн газрын 2012 оны 30 дугаар
Тотоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага |
|-----|--|---------------------|-------------------------|---|---|
| | | | 3 | 4 | |
| 1 | 2 | | | | 5 |
| 1.1 | Иргэдэд түшиглэсэн гамшигаас хамгаалах менежментийг хөгжүүлэх | 2013-2020 | ОБЕГ | | Аймаг, нийспэлийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| 1.2 | Сумын түвшинд гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, боловсруулж үнээзэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, гамшигаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төрийн захирагааны албаны ажиллуулах | 2012-2013 | ОБЕГ | | ЗГХЭГ |
| 1.3 | Төв, орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллага, түүчинэн хувийн хэвшлийн гамшигаас хамгаалах арга хэмжээнд оролцох оролцоог нэмэгдүүлж түншлэх, хамтын ажиллагаа, салбар дундын удирдлагат, зохицуулалтыг боловсронгуй болгох | 2012-2015 | ОБЕГ | | Гамшигаас хамгаалах улсын албад |
| 1.4 | Болоашгүй гамшигийн аюулыг бууруулах арга хэмжээнд олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх | 2015-2020 | ОБЕГ | | Аймаг, нийспэлийн Засаг дарга, олон улсын байгууллага |
| 1.5 | Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшигийн үед авах арга хэмжээний бэлэн байдлын улсын төлөвлөөг шинэчлэн боловсруулах | 2012-2013 | ОБЕГ | | Гамшигаас хамгаалах улсын албад |
| 1.6 | Төв, орон нутгийн томилгоот гамшигаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлын хангах шалтгур үзүүлтийг тогтоо | 2013-2014 | ОБЕГ | | |
| 1.7 | Гамшиг судалалын шинжлэх ухааны хөгжүүлж, түршилт, зохион бүтээх ажлын үр дүнг гамшигаас хамгаалах арга хэмжээнд нэвтрүүлэх | 2012-2020 | ОБЕГ | | Шинжлэх ухааны байгууллага |



| | | | | |
|------|---|-----------|------|--|
| 1.8 | Төв, орон нутгийн төрийн байгууллага, хувийн хэвшлийн гамшигаас хамгаалах мөнхжинийтэй хөгжүүлж, гамшигийн балэн байдлыг шаардлагатай эд материалы, аврах багаж, техник хэрэгслийн наёцийн нэмэгдүүлэх | 2012-2020 | ОБЕГ | Гамшигас хамгаалах улсын албад, аймаг, нийслэлийн Засаг дараа |
| 1.9 | Хөгжлийн бөхжүүлэлтэй ирэд, хүүхэд, өндөр насттан зэрэг нийтийн эмзэг булагийн хэрэгцээ шаардлагыг хангасан бэлэн байдлын тусгай хөтөлбөрийт боловсруунах | 2013-2014 | ОБЕГ | НХХЯ |
| 1.10 | Маргажийн байгуулалтын бие бүрэлдэхүүн, дайчилгаагаар ажилласан байгуулалтын хүн хүч, аюд иргэдийн гамшигийн дараахь зүйлэх сэргээл зүйн хамралтыг багасгах, арилгах үйлчилгээ нөхцөлийг бий болгох | 2013-2016 | ОБЕГ | ЭМЯ |
| 1.11 | Хиллийн боомт болон хиллийн зуурсаас газарт усч болзошгийг гамшигийн аюулаас урьдчилсан сэргийлэх, тохиолдсон уед, түүний захиргааны байгууллага хөорднын төлөвлөх, багаж хэрэгслийн харилцан төлөвлөх, багаж хэрэгслийн хангамжийн сайкруулзах | 2015-2020 | ХХЕГ | ОБЕГ, аймаг, нийслэлийн Засаг дараа |
| 1.12 | Гамшигас хамгаалах чадважийн бэхжүүлэх чиглэлээр хөрш орон, хөөр болон олон улсын байгууллагудтай гол хандивлагч тунц оруууд болон олон улсын байгууллагудтай | 2012-2020 | ОБЕГ | ГХЯ |
| 1.13 | “Аюулгүй зэмнэлэг” үндэсний хөтөлбөр болсовуулж, хэрэгжүүлэх хоёр Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшигийн байдлыг буруулах ажлыг үндэсний хамжээнд зохион байгуулах стратегийн зорилтын хүрээнд | 2013-2015 | ЭМЯ | |
| 2.1 | Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшигийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх | 2012-2016 | ОБЕГ | Гамшигас хамгаалах улсын албад, аймаг, нийслэлийн Засаг дараа, ТББ |
| 2.2 | Эрсдэлийн үнэлгээний аргачалыг учруулж болзошгийг байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшигийн аюул, төв, орон нутгийн газар зүйн байршил, эдийн засаг нийтийн онцлог, түпупурлан боловсронүү болгох | 2012-2015 | ОБЕГ | Гамшигас хамгаалах улсын албад, опон улсын байгууллага |
| 2.3 | Болзошгийн гамшигийн эрсдэл, түүний нэгдүгэнийн талаархи статистикийн мэдээ, өгөгдэхүүний цүглүүлах стандартыг тогтоо, гамшигийн мэдээллийн сангийн Үйлчилгээ болворонүү болгох | 2012-2013 | ОБЕГ | БОАЖЯ, СХЗГ |

| | | | | |
|---|---|-----------|------------------------|---------------------------------------|
| 2.4 | Бус нутгийн болон хил дамнасан болзошгүй гамшигийн эрсдэлийг үнэлэх, байгуулсан гарээ, хэлэлцэрэйн дагуу мэдээлэл солицдох | 2013-2015 | ОБЕГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 2.5 | Гамшигас хамгаалах талаарахи иргэдийн мэдээлжийг дээшүүлэх, ардын уламжлалт арга ухааныг түзэн дэлгэрүүлэх | 2012-2020 | ОБЕГ | БСШУЯ |
| 2.6 | Ур амьстальн өөрчлөлтөөс үзүүлэгчийн эрсдэлийн менежментийн үндэсний дэд хөтөлбөрийн боловсруулж хэрэгжүүлэх | 2012-2013 | ОБЕГ | |
| 2.7 | Жил бүр 2 аймаг, 1 дуурдаг гамшигас хамгаалах иж бураэн штабын сургуулийг зохион байгуулах | 2012-2020 | ОБЕГ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 2.8 | НҮБ-ын Хүмүүнлэгийн хөдлийг зохицуулах албанатай хамтран Хотын дотор эрэн хийх, аврах ажиллагааны олон улсын дадлага талаархи ерөнхий атуulgыг тусгах | 2014 | ОБЕГ | Гамшигас хамгаалах улсын албад |
| 2.9 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн орон сууц, Үйтилээний барилга, байгууламжийн эрсдэлийн үнэлгээ хийх | 2012-2013 | БШСУЯ | |
| 2.10 | Гамшигас урьдчилан сэргийлэх болон гамшигийн үед хүн амьтг хийх | 2013-2017 | | ОБЕГ, гамшигас хамгаалах улсын албад |
| 2.11 | Гамшигас урьдчилан сэргийлэх газар нутгийн үлаанбаатар хотыг хийгдэгийг жангах хүртэл хөгжүүлэх ерөнхий төвлөгөөнд тусгаж, бэлтгэгийг жангах | 2013-2015 | Нийслэлийн Засаг дарга | |
| Гурав. Эхийн орчны боловсроний болгох стратегийн зорилтын хүрээнд | | | | |
| 3.1 | Гамшигас хамгаалах эрх зүйн орчны боловсронгий болгох | 2012-2015 | ОБЕГ | НХХЯ, ГХЯ, СЗХ, даатгалын байгууллага |
| 3.2 | Гальн аюулгүй байдлын дурэм боловсруулах | 2012 | ОБЕГ | |
| 3.3 | Гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалтгынчнын үндэсний хөтөлбөр боловсруулах | 2012 | ОБЕГ | |
| 3.4 | Тамиерын конвенцийд Монгол Улс нэгэн орох асуудлыг судлах | 2012-2014 | ОБЕГ | ГХЯ |
| 3.5 | Орон нутгийн нөөцийн бурдаулэх, захирсан зарцуулах журам болсовсруулж, баттуулах | 2012-2013 | ОБЕГ, ХХААХЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| Дөрөв. Агуулт үзэдэл, болзошгүй гамшигийг тандан судлах, үрьдчилан мэдээлэх арга, технологийн нэвтрүүлж, мэдээллийн хэрэгжээцэд шүүхийн хүрэх арга замыг боловсруулж, эртнээс сэргэжилүүлэх тогтолцоог саижруулах стратегийн зорилтын хүрээнд | | | | |
| 4.1 | Гамшигас хамгаалах үйл ажиллагаанд зайнлас тандан судлах, газар зүйн мэдээллийн системийг нэвтрүүлэх | 2012-2020 | ОБЕГ | МШХХТГ |



| | | | | |
|---|--|-----------|------|------------------------|
| 4.2 | Эрсдээлийн зураглал, мэдээллийг боловсруулах, дамжуулах | 2012-2014 | ОБЕГ | ШУА |
| 4.3 | Болзошгүй гамшигийн аюулын талаар хүн амд түгээх зарлан мэдээллийн техник хөргөслээр хангаж, мэдээллийг хэрэлчэцэд шурхай хүрэх арга замыг боловсронуй болгох, эртнээс сэргэжилүүлэх тогтолцоог сайжруулах. | 2013-2020 | ОБЕГ | МШХТГ |
| 4.4 | Онцгой байдлын албаны мэдээллийн техник болон программ хангамж, мэдээллийн сүлжээг орчин үеийн өндөр хурдны техник, технологиор өрөөтөх | 2012-2016 | ОБЕГ | МШХТГ |
| 4.5 | Болзошгүй гамшигийн төрлиүүдэд зохицон ажиллах өндөр боломж бүхий радио холбооны зантиглааг Онцгой байдлын албаны хэмжээнд байтуулах | 2013-2015 | ОБЕГ | МШХТГ |
| 4.6 | Гамшигийн голомтод ажиллах мэдээлэл, холбооны удирдлын хөдөлгөөнтэй зантиглааг орсон нутгийт байтуулах | 2012-2016 | ОБЕГ | МШХТГ |
| Тав. Гамшигас хамгаалахаан хүч хэрэгслийн чадавхийг бэхжүүлэх стратегийн зорилтын хүрээнд | | | | |
| 5.1 | Аваргчийг мэргэжлийн сургалтын төвөөр бэлтгэх, мэргэшүүлэх | 2012-2020 | ОБЕГ | БСШУЯ |
| 5.2 | Мэргэжлийн боловсон хүчин болгох | 2013-2020 | ОБЕГ | БСШУЯ |
| 5.3 | Аврах, гол унтраах антиг, булэг, бие бурялдэхүүний үргэгүйцэтгээд шаардлагатай аврах ажлын баатж, тоног төхөрөмж, техник хэрэгсэл, тусгай зорилуултын машин механизмын стандарт, норм, нормативыг боловсруулах | 2012-2014 | ОБЕГ | СХЗГ |
| 5.4 | Эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд саргөөр нэлвэлж болзошгүй газар хөдлөлт, үер, цайраг, химийн хорт болон агуултай бодисын хордуулант, бусад гамшигийн хорт уршигийг арилгах аврах ажлын зорилуулттай тусгай баатж, тоног төхөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах | 2012-2020 | ОБЕГ | Олон улсын байгууллага |
| 5.5 | Аврах ажлын зарим баатж, тоног төхөрөмж, техник хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх, засварлах төв байтуулах | 2012-2020 | ОБЕГ | |
| 5.6 | Улсын нийтийн бараа, материалыг хадгалах нөхцөл, технологийг дээшшуулэх | 2012-2020 | ОБЕГ | |

| | | | | |
|------|--|-----------|------------------------|-------------------------------|
| 5.7 | Гамшигийн нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээг чиэтэх, зөвлөлийх ёгех гамшигаас хамгаалах мөнжментийн үндэсний шинжээч болон тадаад улсад хүмүүнэтийн үүрэг гүйцэтгэх аврах багийг бэлтгэх | 2012-2020 | ОБЕГ | ГХЯ |
| 5.8 | Гамшигаас хамгаалах улсын албадын гамшигаас хамгаалах үйл ажиллагааны чадавхийг сийлүүлэх | 2012-2020 | ОБЕГ | Гамшигийн албад |
| 5.9 | Болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осолт, бус нутгийн онцлог, хүн амын төвлөрөл, дэд бүрэл, эзийн засгийн хүчин зүйлиг харгалзан зарим гэмтэлтэй аврах анийн салбар байгуулах | 2012-2020 | ОБЕГ | |
| 5.10 | Аврах, гол үнтраах аниудыг шинээр болон өргөтгөн зөхөн байгуулах | 2012-2020 | ОБЕГ | |
| 5.11 | Хүн амын төвлөрөл ихтэй томоохон хот, бүсийн төвд аврах "Шуурхай булгар" байгуулах | 2013-2020 | ОБЕГ | Аймаг, нийслэлийн засаг дарга |
| 5.12 | Нийслэлийн ачаа тээврийн шалтган нэвтрүүлэх товчоон дээр суурин ажиллагаатай ариутгальн цаг байгуулах | 2015-2020 | Нийслэлийн засаг дарга | |
| 5.13 | Болзошгүй гамшигийн төрөл, бус нутгийн онцлогт нийцүүлэн гамшигийн бэээн байдлын хангах, хор уршигийг арилгах чиглэээр шаардлагатай мөнгөн хөрөнгө, бараа, материал, бараж, техник хэрэгслийн орон нутгийн болон Гамшигаас хамгаалах улсын албаны нөөц бурдуулэх | 2013-2020 | Гамшигийн засаг дарга | |
| 5.14 | Аваргийн бие бялдарын тэсвэр хатуужил, сэргээл зүйн бэлтгэлийг төлөвшүүлэх хээрийн сургалтын төв байгуулах | 2015-2020 | ОБЕГ | СЯ |



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор баталсан "Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм"-ийн 3, 5 дахь заалтын "Үнэт цаасны хороо" гэснийг "Санхүүгийн зохицуулах хороо" гэж, мөн 3 дахь заалтын "Санхүү, эдийн засгийн яам" гэснийг "санхүү, бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага" гэж, 4 дэх заалтын "Санхүү, эдийн засгийн сайдын" гэснийг "санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний" гэж, мөн заалтын хоёр дахь өгүүлбэрийн "Санхүү, эдийн засгийн сайд" гэснийг "Улсын ерөнхий байцаагч" гэж, 5 дахь заалтын "Санхүү, эдийн засгийн яамны" гэснийг "санхүү, бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын" гэж, 12 дахь заалтын "21 дүгээр зүйлд" гэснийг "10.9-д" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Мөн тогтоолоор баталсан 8 дахь заалтын "Ерөнхий байцаагч" гэснийг, 10 дахь заалтын "албан шаардлага, торгууль" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

Д.ХАЯНХЯРВАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

Хурдан морины бүсийн уралдааны 2012 оны хуваарийг тогтоох тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.3, Монголын морин спорт, уяачдын холбооноос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дүнжингарав-2012" Төвийн бүсийн хаврын уралдааныг 2012 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Төв аймагт, Говийн бүсийн хаврын уралдааныг 2012 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Өмнөговь аймагт,

Зүүн бүсийн зуны уралдааныг Сүхбаатар аймагт, Баруун бүсийн зуны уралдааныг Баян-Өлгий аймагт, Говийн бүсийн зуны уралдааныг Дундговь аймагт, Төвийн бүсийн зуны уралдааныг Төв аймагт 2012 оны 7 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2. Дээр дурдсан хурдан морьдын уралдааныг тогтоосон хугацаанд Монголын хурдан морины уралдааны дүрмийн дагуу зохион байгуулахыг холбогдох аймаг болон нийслэлийн Засаг дарга, Монголын морин спорт, уяачдын холбоонд тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Загвар шинэчлэн батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийн үнэмлэхийн загварыг 1 дүгээр, тэмдгийн загварыг 2 дугаар, дүгнэлтийн загварыг 3 дугаар, актын загварыг 4 дүгээр, албан шаардлагын загварыг 5 дугаар, торгуулийн хэвлэмэл хуудасны загварыг 6 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД



Засгийн газрын 2012 оны 38 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

| | | |
|---|--------------------------------------|---|
| Байгууллагын бэлгэдэл | Мэргэжлийн хяналтын байгууллагын нэр | Dугаар |
| Зураг /3x4/ | Dугаар | Монгол Улсын хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, хуульд заасан арга хэмжээ авч, хариуцлага хулээлгэх эрх бүхий албан тушаалтан тул үнэмлэх олгов. |
| Овог: | Улсын байцаагчийн хяналтын чиглэл | The identification card (ID) is issued to authorized state officer to inspect compliance and implementation of laws, regulations and standards of Mongolia, and to take measure and sanctions in obedience to the respective law. |
| Нэр: | | Олгосон огноо: |
| ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ОБЪЕКТОД СААДГҮЙ НЭВТРЭН ОРОН ЭРХТЭЙ | | Хүчинтэй хугацаа: |
| | | МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ |
| | | Гарын үсэг (нэр) |
| | | Үнэмлэхийг зориулалт бусаар ашиглах, бусдад шилжүүлэх, барьцаанд тавихыг хориглоно |

Тайлбар: Улсын байцаагчийн үнэмлэх босоо хэлбэртэй, 2 нүүр байна. Монгол Улсын Мэргэжлийн хяналтын улсын ерөнхий байцаагч, салбарын ерөнхий байцаагч улаан өнгийн, бүсийн улсын ахлах байцаагч, улсын ахлах байцаагчийн үнэмлэх хөх өнгийн, улсын байцаагчийн үнэмлэх ногоон өнгийн, хуулиар эрх олгосон байгууллагын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн үнэмлэх саарал өнгийн хавтастай, хавтасны гадна талд тусгайлан хийсэн мэргэжлийн хяналтын байгууллагын бэлгэдэлтэй байна. Бэлгэдэлийн дээд талд “Мэргэжлийн хяналт”, доод талд “Улсын ерөнхий байцаагч”, “Салбарын улсын ерөнхий байцаагч”, “Бүсийн улсын ахлах байцаагч”, “Улсын ахлах байцаагч”, “Улсын байцаагч” гэсэн үгийг алтан шармалаар бичнэ. Үнэмлэхийн суурь нь цэнхэр тэнгэрийн өнгө, үргэлжилсэн хас хээ байх бөгөөд хяналтын чиглэл, байгууллагын нэртэй хэсэг хөх өнгийн дэвсгэртэй байна.

Засгийн газрын 2012 оны 38 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ТЭМДГИЙН ЗАГВАР



Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 40x40 мм-ийн дөрвөлжин хэлбэртэй байна. Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна. Улсын ерөнхий байцаагчийн тэмдгийн голд нь “МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ” гэсэн үг, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл байрлана. Тэмдгийн дөрвөн өнцөгт загасан нүд, гадна хүрээ, төв хэсгийн хүрээ алхан хээгээр хүрээлэгднэ.



Салбарын улсын ерөнхий байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35x35 мм-ийн дөрвөлжин хэлбэртэй байна. Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна. Салбарын улсын ерөнхий байцаагчийн тэмдгийн голд “САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ” гэсэн үг, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл, доод хэсэгт хувийн дугаар байна. Тэмдгийн дөрвөн өнцөгт загасан нүд, гадна хүрээ төв хэсгийн хүрээ алхан хээгээр хүрээлэгднэ.



Бүсийн улсын ахлах байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35x35 мм-ийн найман талт хэлбэртэй



байна. Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна. Бүсийн улсын ахлах байцаагчийн тэмдгийн хүрээг дагаж “МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА”, төв хэсэгт “БҮСИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ” гэсэн үг, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл, доод талд улсын байцаагчийн хувийн дугаар, загасан нүд байна.



Улсын ахлах байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35x35 мм-ийн 16 талт хэлбэртэй байна. Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна. Улсын ахлах байцаагчийн тэмдгийн хүрээг дагаж “МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА”, “УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ” гэсэн үг, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл, доод талд улсын байцаагчийн хувийн дугаар, загасан нүд байна.



Улсын байцаагчийн тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 35x35 мм-ийн 32 тал бүхий дугуй хэлбэртэй байна. Тэмдгийн үсэг нь кирилл үсгээр бичигдсэн байна. Улсын байцаагчийн тэмдгийн хүрээг дагаж “МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА”, төв хэсэгт “УЛСЫН БАЙЦААГЧ” гэсэн үг, дээд хэсэгт байгууллагын бэлгэдэл, доод талд улсын байцаагчийн хувийн дугаар, загасан нүд байна.



Засгийн газрын 2012 оны 38 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТИЙН ЗАГВАР**



Г

Г

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН

ДҮГНЭЛТ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр
Утас:26-47-86, Факс:(976-51) 26-60-88
E-mail: info@inspection.gov.mn,
www.inspection.gov.mn

№

Г

Г

000000



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2012 он №16 /733/



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН

ДҮГНЭЛТ

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.

www.inspection.gov.mn

№ _____

Г

Г

Г

000000



Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН

БҮСИЙН УЛСЫН

АХЛАХ БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын

хаяг, цахим хаяг, утас байна.

www.inspection.gov.mn

№ _____

Г

Г

000000



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2012 он №16 /733/



Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.
www.inspection.gov.mn

№

Г

Г

000000



Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.
www.inspection.gov.mn

№ _____

Г

Г

000000



Засгийн газрын 2012 оны 38 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АКТЫН ЗАГВАР**



Г

Г

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН АКТ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр
Утас:26-47-86, Факс:(976-51) 26-60-88
E-mail: info@inspection.gov.mn,
www.inspection.gov.mn

№

Г

Г

000000

Г



Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
САЛБАРЫН УЛСЫН

ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН АКТ

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.
www.inspection.gov.mn

№ _____

Г

Г

00000

Г



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2012 он №16 /733/



Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
БУСИЙН УЛСЫН

АХЛАХ БАЙЦААГЧИЙН АКТ

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.
www.inspection.gov.mn

№ _____

Г

Г

000000

Г



Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН АКТ

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.
www.inspection.gov.mn

№ _____

Г

Г

000000



Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН АКТ

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.

www.inspection.gov.mn

№

Г

Г

000000

Засгийн газрын 2012 оны 38 дугаар
тогтооолын 5 дугаар хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГЫН ЗАГВАР**



Г

Г

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН

АЛБАН ШААРДЛАГА


15170 Улаанбаатар хот, Чингисийн дүүрэг
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр
Утас:26-47-86, Факс:(976-51) 26-60-88
E-mail: info@inspection.gov.mn,
www.inspection.gov.mn

№_____

Г

Г

000000





Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН

САЛБАРЫН УЛСЫН

ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН

АЛБАН ШААРДЛАГА

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.

www.inspection.gov.mn

№

Г

Г

000000



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
БУСИЙН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.
www.inspection.gov.mn

№ _____

Г

Г

Г

000000



Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН

АЛБАН ШААРДЛАГА

Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын

хаяг, цахим хаяг, утас байна.


www.inspection.gov.mn

№

Г

Г

000000





Г

Г

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА


Тухайн мэргэжлийн хяналтын байгууллагын
хаяг, цахим хаяг, утас байна.
www.inspection.gov.mn

№

Г

Г

000000





Засгийн газрын 2012 оны 38 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ТОРГУУЛИЙН ХЭВЛЭМЭЛ ХУУДАСНЫ ЗАГВАР**

000000

ТОРГУУЛИЙН ХУУДАС

Дугаар_____

Улсын байцаагчийн дугаар_____

Зөрчил гаргасан хуулийн этгээдийн нэр, хаяг, албан тушаал, утасны дугаар:

.....
.....

Зөрчсөн хууль тогтоомжийн зүйл, заалт:

.....
.....

Харицлага хүлээлгэх хууль тогтоомжийн зүйл, заалт:

.....
.....

Заасныг үндэслэн захиргааны шийтгэл ногдуулав.

Торгууль ногдуулсан: /

/гарын үсэг, тэмдэг/

/улсын байцаагчийн овог нэр/

/Торгуулийн хуудасны хорон хувийг зөрчил гаргасан этгээдэд өгнө/

Огноо:оны.... сар....өдөр

5000

төгрөг

000000

ТОРГУУЛИЙН ХУУДАС

Дугаар_____

Улсын байцаагчийн дугаар_____

Зөрчил гаргасан хуулийн этгээдийн нэр, хаяг, албан тушаал, утасны дугаар:

.....
.....
.....

Зөрчсөн хууль тогтоомжийн зүйл, заалт:

Хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийн зүйл, заалт:

.....
..... -Д

заасныг үндэслэн захиргааны шийтгэл ногдуулав.

Торгууль ногдуулсан: /
/гарын үсэг, тэмдэг/
улсын байцаагчийн овог нэр/

/Торгуулийн хуудасны хорон хувийг зөрчил гаргасан этгээдэд өгнө/

Огноо:оны.... сар....өдөр

2000
төгрөг



000000

ТОРГУУЛИЙН ХУУДАС

Дугаар_____

Улсын байцаагчийн дугаар_____

Зөрчил гаргасан хуулийн этгээдийн нэр, хаяг, албан тушаал, утасны дугаар:

.....

Зөрчсөн хууль тогтоомжийн зүйл, заалт.

.....

Хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийн зүйл, заалт.

.....

..... -Д

заасныг үндэслэн захиргааны шийтгэл ногдуулав.

Торгуул ногоонуулсан: /

/гарын үсэг, тэмдэг/ /улсын байцаагчийн овог нэр/

/Торгуулийн хуудасны хорон хувийг зөрчил гаргасан этгээдэд өгнө/

Огноо:оны.... сар.....өдөр

1000

төгрөг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

“Эрүүл хүүхэд” аян зохион байгуулах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, хүн амыг эрүүлжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 18 хүртэлх насны бүх хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн байдлыг үнэлэн эрүүлжүүлэх зорилгоор 2012 онд “Эрүүл хүүхэд” аяныг улсын хэмжээнд зохион байгуулсугай.

2. “Эрүүл хүүхэд” аяныг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах үүрэг бүхий Удирдах хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, аяныг зохион байгуулах удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. “Эрүүл хүүхэд” аяны эхний шатны үйл ажиллагааны үр дүнг 2012 оны II дугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Удирдах хороонд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2012 оны 39 дүгээр
тогтооолын 1 дүгээр хавсралт

“ЭРҮҮЛ ХҮҮХЭД” АЯНЫГ НЭГДСЭН УДИРДЛАГА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙГЭЭР
ХАНГАХ ҮҮРЭГ БҮХИЙ УДИРДАХ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга

-Монгол Улсын Ерөнхий сайд

Дэд дарга

-Эрүүл мэндийн сайд

Гишүүд:

-Боловсрол, соёл, шинжлэх
ухааны сайд;



- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд;
- Сангийн сайд;
- Нийслэлийн Засаг дарга;
- Ерөнхий сайдын зөвлөх;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга;
- Хүүхдийн төлөө газрын дарга;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн захидал (тохиролцсоноор).

**Нарийн бичгийн
дарга**

-Эрүүл мэндийн яамны эх барих, эмэгтэйчүүдийн тусlamжийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

Засгийн газрын 2012 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

**“ЭРҮҮЛ ХҮҮХЭД” АЯНЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

1.1. Монгол Улсын 18 хүртэлх насны бүх хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн байдлыг үнэлэн, мэргэжлийн эмчийн хяналтад авч цаашид эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахад “Эрүүл хүүхэд” аян (цаашид “аян” гэнэ)-ы зорилго оршино.

Хоёр. Зорилт

2.1. Аяны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:

2.1.1. улсын хэмжээнд 18 хүртэлх насны бүх хүүхдийг эрүүл мэндийн ерөнхий үзлэг болон амны хөндий, чих, хамар хоолойн эмчийн үзлэг оношилгоонд хамруулан, бие бялдрын өсөлт, хөгжилтийн түвшинг тогтоох;

2.1.2. өвчтэй хүүхдийг хяналтад авч цаашид эрүүлжүүлэх.

Гурав. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Мэдээлэл, сургалт сурталчилгаа болон үзлэг, оношилгоо хийх:

3.1.1. хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулах, өвчнийг эрт илрүүлэх талаар хүн амын дунд хийх мэдээлэл, сурталчилгааны удирдамж, аргачлал боловсруулах;

3.1.2. эмч, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулан, үзлэг, шинжилгээ хийх нэгдсэн аргачлалаар хангах;

3.1.3. 18 хүртэлх насын хүүхдийг дотор, амны хөндий, чих, хамар хоолой, нүдний ерөнхий үзлэгт хамруулан бие бялдрын хөгжлийг үнэлэх.

3.2. Өвчин илэрсэн хүүхдийг хяналтад авч, цаашид эмчлэн эрүүлжүүлэх ажил зохион байгуулах:

3.2.1. өвчин илэрсэн хүүхдийг эрүүл мэндийн байгууллагын шатлал тус бүрд хяналтад авч эрүүл мэндийн нэгдэл болон төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд эрүүлжүүлэх арга хэмжээг авах;

3.2.2. үзлэгт хамрагдагсдын мэдээллийг нэгтгэн цахим сан бүрдүүлэх;

3.2.3. эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3.2.4. аяны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Дөрөв. Аяныг зохион байгуулах хугацаа, үе шат

4.1. Аяны үйл ажиллагааг дараахь 2 үе шаттайгаар зохион байгуулна:

4.1.1. нэгдүгээр шат-2012 оны 2 дугаар сарын 1-нээс 2012 оны 5 дугаар сарын 30;

4.1.2. хоёрдугаар шат-2012 оны 6 дугаар сарын 1-нээс 2012 оны 12 дугаар сарын 30.



Тав. Аяны санхүүжилт

5.1. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай 18.0 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

6.1. Аяныг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Удирдах хороо ажиллана. Аяны хүрээнд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг Удирдах хороо батална.

Аяны үйл ажиллагааг зохицуулах ажлын албыг Эрүүл мэндийн сайдын дэргэд батлагдсан орон тоо, бутцэд багтаан ажиллуулна.

6.2. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад Эрүүл мэндийн яам дараахь үүрэг хүлээнэ:

6.2.1. аяны хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах, аяны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх;

6.2.2. санхүүжилтийг бүрдүүлэх, хуваарилах, түүний зарцуулалтад хяналт тавих;

6.2.3. багаж, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах үйл ажиллагааг зохицуулах;

6.2.4. аяны үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа үндэсний болон олон улсын байгууллагын хөтөлбөр, төслийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

6.2.5. аяны хэрэгжилтэд хяналт тавьж, тулгамдсан асуудлыг тухай бүрд нь Удирдах хороонд тавьж шийдвэрлүүлэх.

6.3. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам дараахь үүрэг хүлээнэ:

6.3.1. ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулах;

6.3.2. үзлэг, оношилгоог хийх боломжийг бүрдүүлэх талаар ерөнхий боловсролын сургуулийн удирдлагийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;

6.3.3. сурагчид болон гэр бүл, эцэг эхийн дунд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах.

6.4. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам дараахь үүрэг хүлээнэ:

6.4.1. аяныг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх асуудлыг зохицуулах;

6.4.2. халамжийн төвүүдэд байгаа орон гэргүй хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулах;

6.4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах талаар дэмжлэг үзүүлэх.

6.5. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар дараахь үүрэг хүлээнэ:

6.5.1. 18 хүртэл насны хүүхдийн эрүүл мэндийн талаар цахим бүртгэлийн сан бүрдүүлэх;

6.5.2. аяны хүрээнд хийх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

6.5.3. аяны хэрэгжилтийн тайланг нэгтгэх, иргэдэд мэдээлэх.

6.6. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хүүхдийн төлөө газар аяны үйл ажиллагааг зохион байгуулахад дараахь үүрэг хүлээнэ:

6.6.1. аяны арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

6.6.2. хараа хяналтгүй хүүхдийг үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах.

6.7. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв дараахь үүрэг хүлээнэ:

6.7.1. аяны үйл ажиллагаанд оролцох эмч, мэргэжилтнийг сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулах;

6.7.2. үзлэгийн маягтыг боловсруулж, үзлэг, оношилгооны явцад судалгааны багийг томилон ажиллуулах;

6.7.3. шаардлагатай үед зөвлөх эмч, сургагч-багш нарыг томилон ажиллуулах;



6.7.4. төрөлжсөн, мэргэжлийн үзлэг, оношилгоог хийж эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авах.

6.8. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад аймаг, нийслэлийн Засаг дараах үүрэг хүлээнэ:

6.8.1. харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд аяны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ өгөх;

6.8.2. аяны хэрэгжилтийн тайланг орон нутгийн хэмжээнд нэгтгэн Удирдах хороонд хүргүүлэх.

6.9. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар дараах үүрэг хүлээнэ:

6.9.1. аяны хүрээнд хийх үзлэг, оношилгоог орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;

6.9.2. мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

6.9.3. өрх, сумын эрүүл мэндийн төвийг бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран ажиллах талаар нэгдсэн удирдлагаар хангах.

Долоо. Гүйцэтгэгч байгууллага

7.1. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд нь дараах үүрэг хүлээнэ:

7.1.1. нэгдсэн аргачлалын дагуу хүүхдийн өвчинийг эрт илрүүлэх үзлэг, оношилгоог өрх болон сургуулиар явж хийх, өвчин илэрсэн хүүхдийг бүртгэлд авч холбогдох мэдээллийг дээд шатны эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх;

7.1.2. үзлэгт хамрагдагсдын мэдээллийг үзлэгийн маягтын дагуу бүрдүүлэх;

7.1.3. сургалт сурталчилгааг харьяа нутаг дэвсгэр, ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах.

7.2. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад бүсийн оношилгоо, эмчилгээний төв, эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн эмнэлэг нь дараах үүрэг хүлээнэ:

7.2.1. анхан шатны үзлэг, оношилгоогоор өвчин илэрсэн хүүхдийг хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.2.2. үзлэг, оношилгоогоор өвчин илэрсэн хүүхдийг хянах тогтолцоог бүрдүүлэх, цахим бүртгэлд хамруулах;

7.2.3. зөвлөх эмч, эмнэлзүйн сургагч багш нарыг томилж ажилуулах.

7.3. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд нь дараахь үүрэг хүлээнэ:

7.3.1. аяны хүрээнд өвчин илэрсэн хүүхдийг эрүүлжүүлэх;

7.3.2. мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

7.3.3. бүсийн оношилгоо, эмчилгээний төв, эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр хангах.

Найм. Хамтран ажиллах байгууллага

8.1. Аяны үйл ажиллагааг зохион байгуулахад дараахь байгууллага хамтран ажиллана:

8.1.1. ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлүүд;

8.1.2. Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль;

8.1.3. Нийслэлийн цагдаагийн газар;

8.1.4. ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг;

8.1.5. хүүхдийн асрамж, халамжийн төвүүд;

8.1.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хүүхдийн хорих анги;

8.1.7. төрийн бус байгууллагууд;

8.1.8. хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд.

Ес. Хүлээгдэж байгаа үр дүн

9.1. Аян бүрэн хэрэгжиж дууссанаар дараахь үр дүн гарна:

9.1.1. Монгол Улсын хүүхдийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэнэ;



9.1.2. хүүхдийн дунд зонхилон тохиолдож байгаа өвчнийг илрүүлэн эрүүлжүүлснээр хүн амын өвчлөл буурна;

9.1.3. шүд цоорох өвчний тархалт 10-15 хувиар буурах боломж бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
 хот

“Улсын сайн малчин” шагнал олгох тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын 2 дугаар багийн малчин Чүлтээмийн Аюурзаныг “Улсын сайн малчин”-аар шалгаруулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Т.БАДАМЖУНАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
 хот

Ажлын өдөр шилжүүлэх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 77.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Цагаан сарын баяраар иргэд ажил, амралтаа зөв зохицуулах боломж бүрдүүлэх зорилгоор 2 дугаар сарын 24-ний баасан гарагийн ажлын өдрийг 2 дугаар сарын 18-ны бямба гарагийн амралтын өдөрт шилжүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

“ДЦС-5” төслийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Дулааны цахилгаан станц-5” (“ДЦС-5”)-ын нүүрсний хангамжтай холбогдолтой асуудал болон станцаас үйлдвэрлэх дулаан, цахилгааны эрчим хүчийг хэрэглэгчдэд хүргэхэд шаардлагатай инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг тус станц ашиглалтад орох үед бэлэн байлгах зорилгоор дараах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж, шаардлагатай хөрөнгийг гадаадын зээл, тусламжид хамруулж, 2013 оноос эхлэн улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд Д.Хаянхярваа нарт даалгасугай:

1.1. “ДЦС-5”-ын нүүрсний хангамжийг тогтвортой байлгах зорилгоор Багануурын уурхай, Шивээ-Овоогийн уурхайн нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх техник, технологийн шийдэл, дэд бүтцийн өргөтгөлийн ажлын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, барьж байгуулах.

1.2. “ДЦС-5”-ын үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчийг дамжуулах, түгээх шугам сүлжээ бүхий системийг шинээр байгуулах болон хотын дулаан хангамжийн одоогийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажиллагааны горимын тооцоо хийх, дамжуулах сүлжээ, өргөх станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах, барьж байгуулах.

1.3. “ДЦС-5”-ын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг дамжуулах шугам сүлжээ, хуваарилах байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулах, барьж байгуулах.

1.4. Станцад нүүрс тогтвортой нийлүүлэх зорилгоор “ДЦС-3” төрийн өмчит хувьцаат компанийн салбар төмөр замын сүлжээг өргөтгөх.



2. “ДЦС-5”-ын байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дагуу тус станцын усны хэрэглээг “ДЦС-3”-ын гүний усны худгаас хангах болон шинээр худаг гаргах асуудлыг судалсны үндсэн дээр худгийн цооног өрөмдөх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгож усан хангамжийг баталгаажуулах арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатар, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

3. “ДЦС-5”-ын нүурс тээвэрлэлтийн найдвартай байдлыг хангах зорилгоор Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн Баганур-Улаанбаатар, Шивээ-Овоо-Улаанбаатар чиглэлийн шугамын нэвтрүүлэх чадвар болон Улаанбаатар өртөөний ачаа боловсруулах чадлыг Улаанбаатар хотын тээврийн хөдөлгөөнд хүндрэл үүсгэхгүй нөхцөлтэйгээр нэмэгдүүлэх болон бусад зайлшгүй авах цогц арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, санхүүжилтийн боломжийн талаар тодорхой санал боловсруулан 2012 оны 4 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулж зохих шийдвэр гаргуулахыг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдоржид даалгасугай.

4. “ДЦС-5”-аас гарах үнсний байгаль орчин, хүн амд үзүүлэх нөлөөллийн талаар холбогдох хяналтын болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулсны үндсэн дээр үnsийг цаашид байгаль орчин, хүн амд сөрөг нөлөөлөлгүйгээр хадгалах, ашиглах талаар санал боловсруулан 2012 оны 4 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт оруулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт тус тус даалгасугай.

5. “ДЦС-5” болон түүний дэд бутцийг барихад шаардлагатай бусдын эзэмшилд байгаа газрыг чөлөөлөх, шаардлагатай бол улсын тусгай хэрэгцээнд авах саналыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, 2012 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт оруулахыг Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаярт даалгасугай.

6. Дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих зорилгоор “ДЦС-5” төслийг хэрэгжүүлэхээр сонгогдсон нэгдэлд Монгол Улсын нэгзээс доошгүй хуулийн этгээдийг хувь нийлүүлэгчээр оролцуулсан байх нөхцөл, шаардлагыг уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгаж концесс эзэмшигчийг зохих журмын дагуу шалгаруулахыг Төрийн өмчийн хороонд даалгасугай.

7. “ДЦС-5”-ын үйлдвэрлэсэн цахилгааны эрчим хүч, дулааны эрчим хүчийг худалдан авах талаар төрөөс өгөх баталгааг хангах зорилгоор аккредитив нээх нөхцөлийг тохирон зохих зөвшөөрөл олгох талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхяраад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 3.75

Индекс: 14003